

## ЗАРИМ АШИГТ МАЛТМАЛЫН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ, ЕРӨНХИЙ ЧИГ ХАНДЛАГА

2010 оны 10 сарын 05 өдөр

### Алт:

Дараахь хүснэгтүүдэд 2010 оны 9 сарын 30 хүртэлх алтны үнийг 2009 оны мөн үетэй, 2010 оны эхний 3 улирлын алтны үнийн харьцуулалт мөн 2010 оны 7,8,9 сарын алтны үнийн харьцуулалтыг үзүүлэв. Алтны үнийн өсөлт үргэлжилсээр 2010 оны 9 сарын 24-нд алтны үнэ 1301,60 ам.доллар унц болж үнийн дээд амжилтыг тогтоосон ба өдөр бүр үнийн шинэ дээд амжилтыг тогтоож байна. 9 сарын 29-нд New-York-ийн Comex бирж дээр алтны үнэ 1308,50 ам.доллар/унци байна.


	2009.I-IX	2010.I-IX	2010/2009
Дундаж	930.62	1,178.44	26.6%
Хам.их	1,018.50	1,307.50	28.4%
Хам.бага	810.00	1,058.00	30.6%

	2010.1ул.	2010.2ул.	2010.3ул.	2ул/1ул	3ул/2ул
Дундаж	1,109.73	1,196.74	1,226.80	7.8%	2.5%
Хам.их	1,153.00	1,261.00	1,307.50	9.4%	3.7%
Хам.бага	1,058.00	1,123.50	1,157.00	6.2%	3.0%

	2010.VII	2010.VIII	2010.IX	VIII/VII	IX/VIII
Дундаж	1,192.97	1,215.81	1,271.13	1.9%	4.5%
Хам.их	1,234.00	1,246.00	1,307.50	1.0%	4.9%
Хам.бага	1,157.00	1,187.50	1,240.50	2.6%	4.5%

(Эх сурвалж-Лондонгийн 15 цагийн үнэ-Kitco.com)

Энэ үнийн өсөлтөнд долларын ханшны уналт ба Хятадын алтны хэрэглээ өндөр байгаа нь юлөөлж байна. Алтны хямдралын оргилуе Хятадын 2 ч үндэсний баяртай таарснаар үнэт эдлэлийн борлуулалт маш өндөр байгаа ба Хятадад 1 гр. алтны үнэ 50 ам.доллар буюу 340 юанаас давж байна. Долларын ханшны үргэлжилсэн уналт нь хөрөнгө оруулагчдыг алт, мөнгө гэх мэт найдвартай бүтээгдэхүүнийг сонгоход хүргэж байна. Алтны хэрэглээ ба хөрөнгө оруулалтын байдлаас шалтгаалан ирэх саруудад алтны үнийн өсөлт үргэлжлэх хандлагатай байна.



### Зэс:

Дараахь хүснэгтүүдэд 2010 оны 9 сарын 30 хүртэлх зэсийн үнийг 2009 оны мөн үетэй, 2010 оны эхний 3 улирлын зэсийн үнийн харьцуулалт мөн 2010 оны 7,8,9 сарын зэсийн үнийн харьцуулалтыг үзүүлэв. Лондонгийн Металын Бирж дээр зэсийн нэмэгдсээр 9 сарын 29-нд 8016,50 ам.доллар/тн, 9 сарын 30-нд 8053,25 ам.долларт хүрсэн нь сүүлийн 2 жилийн хамгийн дээд үнийн үзүүлэлт байлаа.


	2009.I-IX	2010.I-IX	2010/2009
Дундаж	4,669.09	7,168.08	53.5%
Хам.их	6,490.25	8,053.25	24.1%
Хам.бага	3,050.25	6,090.75	99.7%

	2010.1ул.	2010.2ул.	2010.3ул.	2ул/1ул	3ул/2ул
Дундаж	7,242.87	7,012.54	7,241.57	-3.2%	3.3%
Хам.их	7,829.75	7,950.25	8,053.25	1.5%	1.3%
Хам.бага	6,241.75	6,090.75	6,353.50	-2.4%	4.3%

	2010.VII	2010.VIII	2010.IX	VIII/VII	IX/VIII
Дундаж	6,734.63	7,283.04	7,708.93	8.1%	5.8%
Хам.их	7,205.50	7,441.75	8,053.25	3.3%	8.2%
Хам.бага	6,353.50	7,066.50	7,516.00	11.2%	6.4%

(Эх сурвалж-LME)

Зэсийн үнийн өсөлтөнд долларын ханшны уналт, зэсийн нөөцийн байдал нөлөөлж байна. Лондонгийн металын биржийн зэсийн нөөц 9 сарын 30-ны байдлаар 950 тн-р буурч 374150 болсон байна. Энэтхэг улсад энэ онд буюу ирэх жилд зэсийн хэрэглээ их нэмэгдэнэ гэж мэдээлж байна. Дэлхий нийтийн зэсийн хэрэглээ 2010 онд 6,9%, 2011 онд 3,8%-р өсөх таамаглалтай. Дэлхийн зэсийн гол үйлдвэрлэгч Чилийн Codelco уурхай энэ жил болон ирэх жилд зэсийн үйлдвэрлэл дэлхий нийтийн эрэлт их байгаатай уялдуулан 1,8 сая тн-р нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна гэж мэдээлсэн байна. 2008 оны 7,8-р сард зэсийн үнэ 8000 ам.доллараас хол давж байсан ба энэ үе дахин давтагдах төлөвтэй байна.



(эх сурвалж-metalprices.com)

## Цайр.

Дараахь хүснэгтүүдэд 2010 оны 9 сарын 30 хүртэлх цайрын үнийг 2009 оны мөн үетэй, 2010 оны эхний 3 улирлын цайрын үнийн харьцуулалт мөн 2010 оны 7,8,9 сарын цайрын үнийн харьцуулалтыг үзүүлэв.


	2009.I-IX	2010.I-IX	2010/2009
Дундаж	1,470.96	2,105.74	43.2%
Хам.их	1,966.50	2,634.25	34.0%
Хам.бага	1,059.25	1,594.75	50.6%

	2010.1ул.	2010.2ул.	2010.3ул.	2ул/1ул	3ул/2ул
Дундаж	2,287.79	2,017.23	2,012.35	-11.8%	-0.2%
Хам.их	2,634.25	2,488.25	2,236.75	-5.5%	-10.1%
Хам.бага	1,980.75	1,594.75	1,726.25	-19.5%	8.2%

	2010.VII	2010.VIII	2010.IX	VIII/VII	IX/VIII
Дундаж	1,843.39	2,044.12	2,151.00	10.9%	5.2%
Хам.их	1,973.25	2,128.25	2,236.75	7.9%	5.1%
Хам.бага	1,726.25	1,941.75	2,088.75	12.5%	7.6%

(Эх сурвалж-LME)

Лондонгийн металын бирж дээр 9сарын 30-нд цайрын үнэ 2176,00 ам.доллар/тн ба 3 сарын цайрын үнэ 12,50 ам.доллараар нэмэгдэж 2220 ам.доллар/тн болсон байна. ILZSG-н судалгаагаар 2010 оны эхний хагаст дэлхий нийтийн цайрын үйлдвэрлэл 6241 сая тн болж 2009 оны мөн үеийнхээс 17% -р өссөн байна. Цайрын хэрэглээ 6047 сая тн болж 13%-р өссөн байна. 2010 оны эхний хагаст дэлхийн цайрын зах зээл 176000 тн-н илүүдэлтэй байгаа бөгөөд 2009 оны эхний хагас жилд 264000 тн илүүдэлтэй байсан гэж ILZSG мэдээлсэн байна. Хятад болон Энэтхэгт цайрын хэрэглээ нэмэгдэж байгаатай уялдан энэ оны 4-р улиралд үнэ чанга хэвээрээ байх төлөвтэй байна.



(эх сурвалж-metalprices.com)

### Хар тугалга:

Дараахь хүснэгтүүдэд 2010 оны 9 сарын 30 хүртэлх хар туналганы үнийг 2009 оны мөн үетэй, 2010 оны эхний 3 улирлын хар тугалганы үнийн харьцуулалт мөн 2010 оны 7,8,9 сарын хар тугалганы үнийн харьцуулалтыг үзүүлэв.


	2009.I-IX	2010.I-IX	2010/2009
Дундаж	1,533.73	2,065.02	34.6%
Хам.их	2,447.25	2,590.50	5.9%
Хам.бага	991.25	1,558.25	57.2%

	2010.1ул.	2010.2ул.	2010.3ул.	2ул/1ул	3ул/2ул
Дундаж	2,218.27	1,943.04	2,030.96	-12.4%	4.5%
Хам.их	2,590.50	2,366.50	2,272.25	-8.6%	-4.0%
Хам.бага	1,924.75	1,558.25	1,692.25	-19.0%	8.6%

	2010.VII	2010.VIII	2010.IX	VIII/VII	IX/VIII
Дундаж	1,836.40	2,074.77	2,183.69	13.0%	5.2%
Хам.их	2,062.50	2,190.25	2,272.25	6.2%	3.7%
Хам.бага	1,692.25	1,936.50	2,088.50	14.4%	7.8%

(эх сурвалж-LME)

Хар тугалганы үнэ сарын 23-с эхлэн 2200 ам.доллар/тн-д хүрсэн ба Лондонгийн металын бирж дээр 1 тн хар тугалга 9 сарын 30-ны байдлаар 2262,00 ам.доллар байна. 2010 оны эхний хагаст дэлхийн боловсруулсан хар тугалганы бүтээгдэхүүн 4285 сая тн болж 2009 оны мөн үеийнхээс 0,8%-р өссөн байна. 2010 оны эхний хагасын байдлаар боловсруулсан хар тугалганы зах зээл 50000 тн-ы илүүдэлтэй байна гэж ILZSG мэдээлсэн байна. 2009 онд Хятадад автомашин ба цахилгаан дугуйны зах зээлийн өсөлтөөс шалтгаалан Хятад улс боловсруулсан хар тугалганы гол импортлогч болон цаашид эрэлт хэрэгцээнээс шалтгаалан үнэ өсөх хандлагатай байна.



(эх сурвалж-metalprices.com)

## Цагаан тугалга:

Дараахь хүснэгтүүдэд 2010 оны 9 сарын 30 хүртэлх цагаан тугалганы үнийг 2009 оны мөн үетэй, 2010 оны эхний 3 улирлын цагаан тугалганы үнийн харьцуулалт мөн 2010 оны 7,8,9-р сарын цагаан тугалганы үнийн харьцуулалтыг үзүүлэв.

	2009.I-IX	2010.I-IX	2010/2009
Дундаж	13,070.50	18,557.66	42.0%
Хам.их	15,847.50	24,625.00	55.4%
Хам.бага	10,052.50	14,937.50	48.6%


	2010.1ул.	2010.2ул.	2010.3ул.	2ул/1ул	3ул/2ул
Дундаж	17,214.44	17,835.94	20,536.85	3.6%	15.1%
Хам.их	18,352.50	19,130.00	24,625.00	4.2%	28.7%
Хам.бага	14,937.50	15,827.50	17,247.50	6.0%	9.0%

	2010.VII	2010.VIII	2010.IX	VIII/VII	IX/VIII
Дундаж	18,182.95	20,743.93	22,693.07	14.1%	9.4%
Хам.их	19,547.50	21,725.00	24,625.00	11.1%	13.3%
Хам.бага	17,247.50	19,772.50	20,872.50	14.6%	5.6%

(эх сурвалж-LME)


Цагаан тугалганы үнэ нэмэгдсээр 24000 ам.доллар/тн -с илүү гарч байгаа бөгөөд 9 сарын 29-нд 24355,00 ам.доллар/тн, 9 сарын 30-нд 24650,00 ам.доллар байна. Лондонгийн Металын бирж дэхь цагаан тугалганы нөөц буурсаар 2010 оны 9сарын байдлаар 12500 тн болсон тул цагаан тугалганы үнэ өсөх хандлагатай байна.

### 2009-2010 оны цагаан тугалганы үнийн байдал



(эх сурвалж-metalprices.com)

**Молибден:** 2010 оны 9 сарын дундаж үнэ 35021,42 ам.доллар/тн байгаа бөгөөд 8 сарын дундаж үнэ 34685 ам.доллар/тн-той харьцуулахад 0,9 %-р 7 сарын дундажүнэ 32004,54 ам.доллар/тн-той харьцуулахад 8,6 %-р өссөн үзүүлэлттэй байна. 2010 оны 9 сарын эхээр 35000 ам. доллар хүрч байсан ба 9 сарын 30 –нд 32400,00 ам.доллар/тн байна. Лондонгийн Металын биржийн нөөц бага байгаа нь үнийн өсөлтөнд нөлөөлөх хандлагатай байна.




(эх сурвалж-metalprices.com)

**Гянтболд (Wolframite):** Үнийн байдлыг харахад 2009 оны 1 сард 166 \$/тн байсан гянтболдын үнэ 2 сараас бууж 150 \$/тн болон оны эцэс хүртэл тогтмол байснаа 2010 оны 1-р сараас нэмэгдэн 3, 4 сард 165 \$/тн хүтэл өсөж 5 -р сараас эхлэн бага зэрэг буурсан байна. Дэлхий нийтийн гянтболдын хэрэгцээнд Хятадын үйлдвэрлэл ба экспорт гол байр суурийг эзэлдэг ба Хятад улс өнгөрсөн 10 жилийн хугацаанд гянтболдын хамгийн том хэрэглэгч болсон байна. Иймд Хятадын засгийн газар нэмэгдэж буй дотоодын хэрэгцээгээ хангахын тулд гянтболдын үйлдвэрлэл ба экспортыг хязгаарлах, импортыг нэмэгдүүлэх бодлого баримталж байна.



(65%-ийн агуулагатай Гянтболдын баяжмал, эх сурвалж -Reuters)

**Төмрийн хүдэр:** 2007 онд дэлхий нийтээр бүхэллэг ба нунтаг төмрийн хүдрийн үнэ бараг 10%-р хорголжин төмрийн хүдэр (pellet)-ийн үнэ 5%-р өссөн ба 2008 онд төмрийн хүдрийн үнэ огцом өссөн байна. Үүнд бүхэллэг ба нунтаг төмрийн хүдрийн үнэ 65% -с илүү, АНУ-н хорголжин төмрийн хүдрийн үнэ 87% -р өссөн үзүүлэлттэй байсан байна. 2009 онд хэдэн жилд үргэлжилсэн үнийн өсөлт өөрчлөгдөж бүхэллэг ба нунтаг төмрийн хүдрийн үнэ 28%-р хорголжин төмрийн хүдрийн үнэ 2 дахин буурсан. 2010 онд төмрийн хүдрийн үнэ дахин нэмэгдэж одоогийн байдлаар төмрийн хүдрийн баяжмалын дундаж үнэ 110\$/тн байна. 2010 оны 4-р улиралд Хятадын төмрийн хүдрийн эрэлт багасаж байгаатай уялдан ВНР, Рио зэрэг компаниудээ 11% -р багасгах хандлагатай байгаа бөгөөд үүнтэй уялдан төмрийн хүдрийн үнэ буурч магадгүй байна.



(Эх сурвалж-metaltorg.ru)

**АМГ-ЫН УУЛ УУРХАЙ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС**

## **2010 оны 10 сарын 11-ний үнийн байдал**

**Алт**-1341,50 ам.доллар/унци

**Зэс**- 10.07-8262 ам.доллар/тн

10.08-8165ам.доллар/тн

**Цайр**-10.07-2302 ам.доллар/тн

10.08-2332 ам.доллар/тн

**Хар тугалга** – 10.06-2294 ам.доллар/тн /Нөөц нь нилээд байгаа./

10.08/-2199 ам.доллар/тн

**Цагаан тугалга**-Нэмэгдсээр -10.08-26025 ам.доллар/тн /Нөөц бага байгаа.